

Монгол Улс: ОУВС-гийн Дүрмийн IV заалтын 2025 оны зөвлөлдөх хэлэлцүүлгийг дүгнэж Ажлын хэсгээс гаргасан мэдэгдэл

ШУУД НИЙТЛЭХ

Дүгнэлтийн мэдэгдэл нь ОУВС-гийн ажлын хэсгийн ихэнх тохиолдолд гишүүн оронд хийсэн албан ёсны айлчлал (эсхүл ‘ажлын айлчлал’)-ын төгсгөлд гаргасан урьдчилсан дүгнэлтийг танилцуулдаг. ОУВС-гийн [Дүрмийн IV](#) заалтын дагуу ОУВС-гийн санхүүжилтийг ашиглах (ОУВС-гаас зээл авах) хүсэлтийг судлах, ОУВС-гийн ажлын хэсгийн хяналт дор хэрэгжиж буй хөтөлбөрийн яриа хэлэлцээ явуулах, эсвэл эдийн засагт гарсан өөрчлөлтүүдэд хяналт шинжилгээ хийх зорилгоор ажлын хэсгийн зөвлөлдөх айлчлалыг гишүүн оронд тогтмол (гол төлөв жил бүр) хийдэг.

Эрх баригчид энэхүү мэдэгдлийг хэвлэн нийтлэх зөвшөөрлийг олгосон болно. Энэ мэдэгдэлд илэрхийлсэн байр суурь нь ОУВС-гийн ажлын хэсгийн байр суурь бөгөөд ОУВС-гийн Захирлуудын зөвлөлийн байр суурийг илэрхийлэхгүй болно. Энэхүү айлчлалын урьдчилсан дүгнэлтэд үндэслэн ажлын хэсэг тайлан боловсруулж, ОУВС-гийн удирдлагад танилцуулан зөвшөөрөл авсны үндсэн дээр ОУВС-гийн Захирлуудын зөвлөлөөр хэлэлцүүлж, шийдвэр гаргуулна.

Вашингтон хот, КТ– 2025 оны 6-р сарын 27: Олон улсын валютын сан (ОУВС)-гийн ноён Тахсин Саади Седикээр ахлуулсан ажлын хэсэг ОУВС-гийн Дүрмийн IV заалтын 2025 оны зөвлөлдөх хэлэлцүүлгийн хүрээнд Монгол Улсын эрх баригчидтай 2025 оны 6-р сарын 4–18-ны өдрүүдэд Улаанбаатар хотноо яриа хэлэлцээ хийлээ. Айлчлалын төгсгөлд ажлын хэсэг үндсэн дүгнэлт, зөвлөмжүүдээ нэгтгэн дараах мэдэгдлийг гаргалаа. Үүнд:

- 2023–2024 онуудад нүүрсний экспорт түүхэн дээд хэмжээнд хүрч, Засгийн газрын зардал өссөнөөр эдийн засгийн идэвхжил ихээхэн нэмэгдэж, улмаар төсвийн тэнцэл эерэг гарч, өрийн дахин санхүүжилтийг амжилттай хэрэгжүүлсэн нь эдийн засгийн эмзэг байдлыг бууруулахад эергээр нөлөөлсөн.
- Байгалийн баялагт суурилсан өсөлт саарахтай зэрэгцээд эрсдэл нэмэгдэж байна. Сүүлийн саруудад нүүрсний экспорт буурч байгаа нь голчлон нүүрсний үнийн уналтаас шалтгаалсан бөгөөд дэлхийн эдийн засгийн тодорхой бус байдал нэмэгдсэнээр ойрын хугацааны төлөв таагүй болж, бодлогын орон зай хязгаарлагдмал байгаа энэ үед сөргөөр нөлөөлж болзошгүй эрсдэлүүд нэмэгдэв.
- Дотоод болон гадаад тэнцвэрийг сэргээх, бодлогын орон зайг хамгаалах замаар сөргөөр нөлөөлж болзошгүй эрсдэлийг даах чадварыг нэмэгдүүлэх нь бодлогын тэргүүлэх чиглэл болж байна. Үүний тулд төсвийн зохистой бодлого баримталж, төсвийн тусгай шаардлагуудыг дагаж мөрдөх, мөнгөний болон макро зохистой бодлогыг чангатгах, ханшийн уян хатан байдлыг нэмэгдүүлэх шаардлагатай байна.

- Хэрэв сөргөөр нөлөөлж болзошгүй эрсдэлүүд бодитоор илэрвэл макро эдийн засаг болон санхүүгийн тогтвортой байдлыг хамгаалахын тулд бодлогын томоохон тохиргоог цаг тухайд нь хийх, ялангуяа төсвийн бодлогыг хатууруулах шаардлагатай болно.

ЭДИЙН ЗАСАГТ СҮҮЛИЙН ҮЕД ГАРСАН ӨӨРЧЛӨЛТҮҮД, ЦААШДЫН ТӨЛӨВ БАЙДАЛ, ЭРСДЭЛҮҮД

Дүрмийн IV заалтын 2023 оны зөвлөлдөх хэлэлцүүлгээс хойш Монгол Улсын макро эдийн засгийн нөхцөл байдал сайжирсан. 2023–2024 онуудад байгалийн баялагт суурилсан эдийн засгийн тэлэлт хөдөө аж ахуйн салбарын огцом агшилтыг үл харгалзан эдийн засгийн идэвхжилийг маш ихээр дэмжсэн. Төсвийн зардал их хэмжээгээр нэмэгдсэн ч уул уурхайн салбараас төсөвт төвлөрүүлсэн орлого хоёр дахин өссөн нь төсвийн тэнцэл ашигтай гарах нөхцөлийг бүрдүүлж, гадаад валютын нөөц болон Үндэсний баялгийн сангийн хуримтлалд эерэг нөлөө үзүүлсэн бөгөөд өрийн эргэн төлөлтүүд хийгдсэн нь ДНБ-д эзлэх өрийн хэмжээ 2022 онд 64.5 хувь байснаас 2024 онд 44.2 хувь (ОУВС-гийн ажлын хэсгийн тодорхойлолтоор) болж буурахад нөлөөлсөн. Зээлжих зэрэглэл тогтоогч байгууллагууд Монгол Улсын зээлжих зэрэглэлийг B+/B2 болгон ахиулж, дэлхий дахинд өрнөсөн худалдааны зөрчилдөөний нөлөөгөөр хэлбэлзэл огцом нэмэгдэхээс өмнө эрсдэлийн нэмэгдэл түүхэн доод түвшинд хүрсэн. ОУВС-гийн “Засгийн газрын эрсдэл ба өрийн тогтвортой байдлын үнэлгээний хүрээ” (SRDSF)-ний дагуу Монгол Улсын өрийн эрсдэлийн түвшин 2023 оны өндөр эрсдэлтэй ангилалд байснаас дунд эрсдэлтэй ангилал рүү шилжлээ. Гэсэн хэдий ч 2023–2024 онуудад Засгийн газрын зардал, тэр дундаа цалин болон хөрөнгө оруулалтын зардал огцом өсөж төсвийн бодлого хэт тэлж, үүнтэй зэрэгцээд бодлогын хүүг бууруулахын хамт заавал байлгах нөөцийн шаардлагыг чангаруулсан хэдий ч зээлийн хурдацтай өсөлт, инфляцын дарамтыг нэмэгдүүлж, улмаар импорт огцом өсөж, ашигтай байсан урсгал тэнцэл 2024 онд алдагдалтай гарсан.

2025 оны эхээр түүхий эдийн огцом өсөлтийн эрч саарч, эдийн засгийн төлөв сулран, сөргөөр нөлөөлж болзошгүй эрсдэлүүд нэмэгдлээ. Үнийн уналтаас шалтгаалан нүүрсний экспортын орлого огцом буурсан нь төсвийн орлого их хэмжээгээр тасрахад хүргэж, урсгал тэнцлийн алдагдлыг улам нэмэгдүүлэн, улмаар гадаад валютын нөөц буурах, төгрөгийн ханш сулрахад хүргэсэн. Зээлийн өсөлт болон инфляц сүүлийн үед бага зэрэг буурах хандлагатай байгааг эс тооцвол өндөр хэвээр байгаа бөгөөд инфляц нь Монголбанкны зорилтот интервалаас давсан хэвээр байна.

ӨСӨЛТИЙН ТӨЛӨВ МУУДАЖ, ЭРСДЭЛ НЭМЭГДЭЖ БАЙГАА ҮЕД БАРИМТЛАХ БОДЛОГО

Төсвийн бодлого

Гадаад болон дотоод тэнцвэрийг сэргээж, төсвийн бодлогын орон зайг хадгалж үлдэхийн тулд төсвийн зохистой бодлого баримталж, төсвийн тусгай шаардлагуудыг дагаж мөрдөх нь нэн чухал байна. Төсвийн орлого буурсан хэдий ч, 2025 оны төсөв болон саяхан батлагдсан дунд хугацааны төсвийн хүрээний баримт бичигт тусгагдсан төсвийн тогтворжуулсан тэнцлийн зорилтыг эрх баригчид төсвийн зарлагыг хязгаарлах замаар хангахаар төлөвлөж байна. Үүнийг

хэрэгжүүлэхийн тулд Засгийн газар бодитой арга хэмжээнүүдийг нарийвчлан боловсруулах шаардлагатай. Ингэхдээ эдгээр арга хэмжээнүүд нь хамгийн эмзэг бүлгийг хамгаалахын тулд нийгмийн зардлыг хамгаалж, хадгалах нь нэн чухал юм. Хэрэв өсөлт саарах эрсдэл бодитоор илэрвэл макро эдийн засгийн тогтвортой байдлыг хамгаалахын тулд төсвийн алдагдал, улсын өрийг бууруулах том зорилт бүхий стратегийг хэрэгжүүлэх шаардлагатай болно. Төсвийн тусгай шаардлагуудыг бодитоор хэрэгжүүлж, төсвийн бодлогын гол тулгуур болгохын тулд тусгай шаардлагуудыг чанд дагаж мөрдөх нь туйлын чухал байна. Тухайлбал томоохон хөрөнгө оруулалтын төслүүдийг Төсвийн тогтвортой байдлын тухай хуульд заасан төсвийн алдагдал болон өрийн тусгай шаардлагуудын хүрээнд хэрэгжүүлэх нь зүйтэй.

Одоогоор яригдаж буй татварын шинэчлэлийг нэн тэргүүнд эргэж авч үзэх шаардлагатай. Шинэчлэлийн хүрээнд татварын удирдлагыг боловсронгуй болгох, НӨАТ-ын суурийг тэлэх, цахим үйлчилгээний татварыг нэвтрүүлэх, прогрессив татварын тогтолцоог бэхжүүлэх зэрэг нааштай бодлогууд тусгагдсан боловч энэ нь уул уурхайн бус татварын орлогыг их хэмжээгээр бууруулж, энэ нь цаашид байнга үргэлжлэхээр байна. Ингэснээр төсвийн нийт алдагдал нэмэгдэж, Засгийн газрын хөгжлийн нэн шаардлагатай төслүүдийг хэрэгжүүлэхэд шаардлагатай төсвийн орон зайг хумин тусгай шаардлагуудыг дагаж мөрдөх чадварыг бууруулаад зогсохгүй төсвийг уул уурхайн орлогын хэлбэлзэлд илүү өртөмтгий болгоно. Түүнчлэн санал болгож буй шинэчлэлийн зарим хэсгийг олон улсын шилдэг туршлагатай нийцүүлж илүү боловсронгуй болгох нь зүйтэй. Мөн шинэчлэлийн хүрээнд багтаасан прогрессив НӨАТ зэрэг зарим арга хэмжээг хэрэгжүүлэхэд Монголын татварын тогтолцоо хараахан бэлэн биш байна. Үүний оронд, шинэчлэлийн хүрээнд татварын хөнгөлөлт чөлөөлөлтийг оновчтой болгох, татварын өр төлбөрийг барагдуулах, татвар, гаалийн удирдлагын шинэчлэлийг хэрэгжүүлэх замаар уул уурхайн бус орлогыг нэмэгдүүлэхэд төвлөрөх нь зүйтэй.

Төсвийн эрсдэлийг бууруулах зорилгоор нэмэлт зарим шинэчлэлийг авч хэрэгжүүлэх шаардлагатай байна. Нийгмийн халамжийг зорилтот бүлэгт чиглүүлэхэд түлхүү анхаарснаар уул уурхайн баялгийн шударга бус хуваарилалттай холбоотой олон нийтийн дунд байдаг ойлголтыг арилгахад тусална. Мега төслүүдийг гадаад санхүүжилтийн олдоц, эдийн засгийн шингээх чадварыг харгалзан эрэмбэлэх нь зүйтэй. Орон нутгийн засаг захиргаатай уялдаа холбоог сайжруулж нэгдсэн төсвийн сахилга батыг хангах нь зүйтэй. Төрийн өмчит компани (ТӨК) болон төр, хувийн хэвшлийн түншлэл (ТХХТ)-ийн эрх зүйн орчныг сайжруулах хэрэгтэй. Сангийн яамны төсвийн эрсдэлд хяналт шалгалт хийх, эрсдэлийг бууруулах чиглэлээр гаргаж байгаа хүчин чармайлт дээр суурилан чадавхыг улам бэхжүүлэх шаардлагатай байна. Монгол Улсын Хөгжлийн банкны тайлан тэнцэл, засаглалтай холбоотой удаан хүлээгдэж буй асуудлуудыг шуурхай шийдвэрлэх шаардлагатай. Засгийн газрын дотоодод гаргах үнэт цаасны хэмжээг нэмэгдүүлэх нь жишиг өгөөжийн муруйг бий болгож, дотоодын санхүүгийн зах зээлийг хөгжүүлэх болон Монгол Улсын гадаад зээлийн хамаарлыг бууруулахад эергээр нөлөөлөх юм.

Мөнгөний болон валютын ханшийн бодлого

Зээлийн өсөлт болон инфляцыг хязгаарлахын тулд дотоодын санхүүгийн нөхцөлийг хатуу хэвээр байлгах хэрэгтэй. 2025 оны эхээр бодлогын хүүг өсгөж, сүүлийн саруудад инфляц бага

зэрэг саарсан хэдий ч 2025–2026 онуудад Монголбанкны зорилтот интервалаас давах төлөвтэй байна. Хэрэв валютын ханш болон бусад шалтгаанаар инфляцын буурах хандлага эргэж өөрчлөгдвөл, бодлогын хүүг нэмэгдүүлэх шаардлага үүсэж болзошгүй. Түүнчлэн, заавал байлгах нөөцийн шаардлагад тохиргоо хийх орон зай байна. Заавал байлгах нөөцөд хэт их найдах нь банкнуудын хувьд заавал байлгах нөөцөөс чөлөөлөгддөг буюу нэг жилээс урт хугацаагаар гадаад зах зээлээс эх үүсвэр босгох эрмэлзлийг нэмэгдүүлж болзошгүй байгаа бөгөөд энэ нь Монголбанкны банкнуудтай хийж буй гадаад валютын своп хэлцлээр дамжуулан төв банкны ханшийн эрсдэлд өртөх магадлалыг нэмэгдүүлж байна.

Валютын ханшийн уян хатан байдлыг нэмэгдүүлснээр Монгол Улсын гадаад шокийн эрсдэл даах чадварыг бэхжүүлэхээр байна. Монголбанк нь зах зээлийн тааламжтай нөхцөл бүрдсэн үед боломж ашиглан гадаад валютын нөөцөө нэмэгдүүлэх стратеги баримтлах хэрэгтэй.

Монголбанк валютын захын зуучлагч, валютын тогтмол нийлүүлэгч байх оролцоогоо аажмаар бууруулж, валютын ханшийг зах зээлийн эрэлт, нийлүүлэлтээр тогтоох илүү үр дүнтэй механизмыг бүрдүүлэхийг дэмжин ажиллах хэрэгтэй. Мөн түүнчлэн, Монголбанк дотоодод валютын үүсмэл хэрэгслийн захыг хөгжүүлэхэд дэмжлэг үзүүлж, ханшийн эрсдэлээс хамгаалах арга хэрэгслийг банкнуудад дангаар нийлүүлдэг үүргээсээ аажмаар татгалзах нь зүйтэй.

Монголбанкны бодлого, үйл ажиллагаа үр дүнтэй байх нөхцөлийг нэмэгдүүлэх шинэчлэлийг эрчимжүүлэх шаардлагатай. Хөнгөлөлттэй хүүтэй ипотекийн зээлийн хөтөлбөр нь мөнгөний бодлогын шилжих механизмын үр нөлөөг хязгаарлаж, төв банкны хараат бус байдалд сөргөөр нөлөөлж байгаа учраас Монголбанк энэ үйл ажиллагаанаас бүхэлдээ татгалзах нь нэн чухал байна. Засгийн газар ипотекийн зээлийн хөтөлбөрийг Монголбанкнаас шилжүүлэн авч, мөн шинээр байгуулагдсан Хуримтлалын сангийн хөрөнгийг орон сууцны зээлийн хөтөлбөрт чиглүүлэх үүргээс Монголбанкийг чөлөөлөх шаардлагатай. Мөн түүнчлэн, Монголбанкны үндсэн үүрэг, үйл ажиллагааны бие даасан байдал, засаглалыг бэхжүүлэх зорилгоор хийхээр төлөвлөж буй Төв банкны тухай хуулийн нэмэлт өөрчлөлтийг эцэслэн боловсруулж, УИХ-д өргөн барих хэрэгтэй байна. Сангийн яам болон Монголбанк нь төв банкны өөрийн хөрөнгийг төсвийн тогтвортой байдалд нийцтэйгээр, үе шаттайгаар нэмэгдүүлэх стратегийг тодорхойлсон харилцан ойлголцлын санамж бичиг дээр тохиролцох шаардлагатай.

Макро зохистой болон санхүүгийн салбарын бодлого

Санхүүгийн тогтвортой байдлын эрсдэл, тэр дундаа зээлийн хурдацтай өсөлтөөс үүдэлтэй эрсдэлийг бууруулахын тулд макро зохистой бодлого болон санхүүгийн хяналт шалгалтыг бэхжүүлэх шаардлагатай. Банк болон банк бус санхүүгийн байгууллагууд (ББСБ)-ын шинээр олгож байгаа зээл дээр тавигдах өр, орлогын харьцааны дээд хязгаарыг бууруулсан зэрэг макро зохистой арга хэмжээнүүдийг чангатгасан нь сайшаалтай юм. Гэсэн хэдий ч нэмэлт арга хэмжээнүүд, тухайлбал, ББСБ-д тавигдах өр, орлогын харьцааны шалгуурыг банкнуудынхтай нийцүүлэх, мөн Монголбанкны макро зохистой бодлогын хэрэгслийн хүрээг өргөтгөж, мөчлөг сөрсөн өөрийн хөрөнгийн нөөц шаардлага, хөрвөх чадварын хүрэлцээний харьцаа (LCR), тогтвортой цэвэр санхүүжилтийн харьцаа (NSFR)-г зохицуулалтад нэвтрүүлэх шаардлагатай байна. Макро зохистой бодлого болон мөнгөний бодлогыг зааглан боловсруулж, хэрэгжүүлэх нь зүйтэй.

Хяналт шалгалтыг эрсдэлд суурилсан, ирээдүйд чиглэсэн арга зүйд шилжүүлж байгаа нь эерэг өөрчлөлт юм. Банкнууд болон ББСБ-уудын харилцан хамаарлыг анхааралтай ажиглаж, хяналт тавих шаардлагатай. Хянан шалгагч нарын эрх зүйн хамгаалалтыг сайжруулах, зохицуулагч байгууллага хоорондын мэдээлэл солилцоо, уялдааг илүү үр дүнтэй болгох чиглэлээр Төв банк (Монголбанк) болон Банкны тухай хуулиудад нэмэлт өөрчлөлт оруулах нь нэн чухал шаардлагатай байна. Мөн хямралын үеийн удирдлага зохицуулалтыг сайжруулах, банкны бүтцийн өөрчлөлтийн арга хэмжээг хэрэгжүүлэхэд ашиглаж болох эх үүсвэрийг тодорхой болгох нь санхүүгийн тогтвортой байдлын эрсдэлийг бууруулахад ач холбогдолтой байна.

Мөн зээлжих чадвар сайтай зээлдэгчдэд зээл олгох хүрээнд санхүүгийн салбарын чадавхыг бэхжүүлэх чиглэлээр шинэчлэлийн арга хэмжээ авах шаардлагатай байна. Энэ шинэчлэлийн зорилго нь нэн ялангуяа жижиг, дунд бизнесийн зээлийн өртгийг бууруулахад оршиж байна. Энэ хүрээнд Зээлийн мэдээллийн сан болон Төлбөрийн чадваргүйдлийн тухай хуульд нэмэлт өөрчлөлт оруулах замаар зээлийн судалгаа шинжилгээ, барьцаа хөрөнгийн үнэлгээг илүү үр дүнтэй бөгөөд цаг тухай бүрд хийх нөхцөлийг бүрдүүлэх, барьцаа хөрөнгө хураах, төлбөрийн чадваргүйдлийн үед авч хэрэгжүүлэх үйл ажиллагааг хялбаршуулах хэрэгтэй. Мөн түүнчлэн, банкны хувьцаа эзэмшлийн бүтцийг төрөлжүүлэх ажлыг үргэлжлүүлэх нь зүйтэй бөгөөд энэ хүрээнд нэг хувьцаа эзэмшигчид тавигдах өмчлөлийн дээд хязгаарыг нэмэгдүүлэх, олон банканд нэгэн зэрэг хөрөнгө оруулах боломжийг бүрдүүлэх шаардлага үүсэхээр байна. Үүний зэрэгцээ нарийн төвөгтэй өмчлөлийн бүтэцтэй банкны хяналт шалгалтыг үр дүнтэй хэрэгжүүлснээр банкны хамаарал бүхий болон холбогдох этгээдийн зээлтэй холбогдон гарах эрсдэлийг бууруулах үр нөлөөтэй байна.

Бүтцийн бодлого

Сүүлийн жилүүдэд бизнесийн орчин болон засаглалыг сайжруулахад гаргасан ахиц дэвшлийг улам төгөлдөржүүлэх нь Монгол Улсын урт хугацааны өсөлтийн төлөвийг сайжруулна. Одоогоор эдийн засагт төрийн оролцоо өндөр, хууль, эрх зүйн орчин удаа дараа өөрчлөгдөж байгаа нь хувийн хэвшлийн санаачилгыг дарж, гадаадын шууд хөрөнгө оруулалтыг татахад сөргөөр нөлөөлж байна. Шинэчлэлийн хүрээнд хүнд суртлыг багасгах, тусгай зөвшөөрөл олгох шат дамжлагыг хялбаршуулах, татварын хууль тогтоомжийн мөрдөлт нийцэл, газар ашиглалтын тогтолцоог сайжруулах, шүүх, зохицуулах байгууллагын шийдвэрийн хэрэгжилтийг ил тод, тогтвортой болгох чиглэлд анхаарах хэрэгтэй. Мөн төрийн байгууллагуудын засаглалыг бэхжүүлэх шаардлагатай байна. Тухайлбал, төсвийн орлого бүрдүүлдэг байгууллагууд дахь авлигын эрсдэлийг бууруулах, төрийн худалдан авалт болон төрийн өмчит компаниуд (ТӨК)-ын ил тод байдал, хариуцлагыг сайжруулах, ТӨК-ийн тухай хууль, Шүтэл үлээгчийн эрх зүйн байдлын тухай хууль зэрэг хууль эрх зүйн шинэчлэлийг хэрэгжүүлэх нь зүйтэй. Монгол Улс мөнгө угаах болон терроризмыг санхүүжүүлэхтэй тэмцэх хууль эрх зүйн орчныг сайжруулах чиглэлээр хангалттай ахиц дэвшил гаргасан ч үр дүнтэй хэрэгжүүлэхэд сорилтууд байсаар байна.

Уур амьсгалын өөрчлөлтийн нөлөөг сааруулах, дасан зохицох, ногоон шилжилтийг хэрэгжүүлэхэд их хэмжээний хөрөнгө оруулалт, бодлогын шинэчлэл хийх шаардлагатай байна. Хүнд хахир өвөл, үер зэрэг байгалийн гамшигт үзэгдлийн давтамж, эрчимжилт нэмэгдэж байгаа учраас дасан зохицох арга хэмжээг авч хэрэгжүүлэн, Монгол Улсын эдийн засгийн

салбарууд нүүрстөрөгч ихээр үйлдвэрлэж байгааг шийдвэрлэх, агаарын бохирдлыг бууруулах чиглэлээр нөлөөллийг бууруулах арга хэмжээг авч хэрэгжүүлэх шаардлагатай байна. Цаашилбал, БНХАУ эрчим хүчний шилжилт, нүүрстөрөгчгүйжүүлэх бодлогоо эрчимжүүлж байгаатай холбоотойгоор нүүрсний эрэлт буурах хүлээлтийг харгалзан Монгол Улс урьдчилан бэлтгэх шаардлагатай. Өнөөдрийн байдлаар Монгол Улсын уур амьсгалын өөрчлөлтийн бодлогын хэрэгжилт хангалтгүй байсаар байна. Уур амьсгалын өөрчлөлтөд дасан зохицох арга хэмжээнүүд салбарын бодлого, төсвийн тогтолцоонд бүрэн тусгагдаагүй байна. Цаашилбал, салбар хоорондын уялдааг хангах шаардлагыг тусгасан уур амьсгалын өөрчлөлтийн тухай тусгай хууль одоогоор байхгүй байна. Монгол Улсын уур амьсгалын зорилтуудыг хэрэгжүүлэхэд төр болон хувийн хэвшлээс их хэмжээний санхүүжилт шаардлагатай болох тул төсвийн орон зайг бий болгох нь нэн чухал байна.

ОУВС-гийн ажлын хэсгийг найрсаг дотно хүлээн авч, илэн далангүй, үр бүтээлтэй яриа хэлэлцээ өрнүүлсэн Монгол Улсын эрх баригчид, төрийн болон хувийн хэвшлийн олон салбарын төлөөлөлд чин сэтгэлийн талархал илэрхийлж байна.

Хүснэгт 1. Монгол Улс: Эдийн засаг, санхүүгийн зарим үзүүлэлтүүд, 2022-2030 онууд

	2022	2023	2024	2025	2026	2027	2028	2029	2030
	Гүйцэтгэл			Төсөөлөл					
	(өөрөөр заагаагүй бол ДНБ-д эзлэх хувиар)								
Үндэсний тооцоо									
ДНБ-ий бодит өсөлт (өөрчлөлт, хувиар)	5.0	7.4	4.9	5.5	5.5	5.5	5.3	5.0	5.0
ДНБ, оны үнээр (сая ам. доллар)	17,146	20,315	23,586	...	...	...	...	...	...
ДНБ (зэрэгцүүлэх үнэ) дэх оролцоо (нэгж хувиар)									
Дотоод эрэлт	11.4	5.6	21.2	6.6	4.4	7.1	7.2	6.5	6.2
Бараа үйлчилгээний экспорт	13.9	17.9	0.5	4.2	5.4	2.8	2.3	1.7	1.8
Бараа үйлчилгээний импорт	-20.3	-16.2	-16.8	-5.3	-4.2	-4.4	-4.2	-3.3	-3.0
Хэрэглээ	65.8	57.5	66.1	72.1	72.0	72.5	72.5	73.0	73.0
Хувийн сектор	51.9	44.5	49.8	55.6	55.9	56.6	56.6	57.2	57.3
Улсын	13.9	13.0	16.3	16.5	16.1	16.0	15.9	15.8	15.7
Хөрөнгийн нийт хуримтлал	42.3	33.9	34.6	32.3	30.7	30.7	30.9	30.7	30.4
Үндсэн хөрөнгийн нийт хуримтлал	29.8	25.3	26.8	24.3	23.7	23.7	23.9	23.7	23.4
Төрийн байгууллага	7.1	7.4	9.9	8.3	8.0	7.9	7.8	7.8	7.9
Гадаадын шууд хөрөнгө оруулалт	14.2	10.7	11.6	9.5	9.0	8.8	8.6	7.8	7.7
Дотоод хувийн сектор (ТӨК-ийг оруулсан)	8.6	7.3	5.3	6.5	6.7	7.0	7.5	8.0	7.8
Үндэсний нийт хуримтлал	28.9	34.5	24.1	17.5	17.6	17.4	17.9	17.8	17.7
Үнэ									
Хэрэглээний үнэ (дундаж; өөрчлөлт хувиар)	15.1	10.4	6.2	8.7	8.6	7.9	7.2	6.7	6.4
Хэрэглээний үнэ (хугацааны эцэст; өөрчлөлт хувиар)	13.3	7.7	8.3	9.0	8.2	7.5	6.8	6.5	6.2
Зэсийн үнэ (нэгж тонн ам. доллар)	8,829	8,491	9,142	8,981	8,897	8,983	9,056	9,122	9,167
Нүүрсний үнэ (нэгж тонн ам. доллар)	123	131	107	68	73	72	72	72	72
ДНБ-ий дефлятор (өөрчлөлт хувиар)	17.7	21.8	8.2	6.1	8.0	7.5	7.3	6.5	6.5
Засгийн газрын данс 1/									
Суурь тэнцэл (ОУВС-гийн тодорхойлолтоор)	2.2	4.3	2.8	1.0	0.5	-1.0	-0.8	-0.8	-0.7
Нийт орлого, тусламжийн дүн	34.4	34.6	39.2	35.1	33.6	31.5	31.2	31.1	30.9
Суурь зарлага, цэвэр зээл	32.2	30.3	36.5	34.1	33.0	32.5	32.1	31.8	31.6
Хүүгийн зардал	1.5	1.6	1.5	1.7	1.9	2.1	2.2	2.4	2.5
Нийт тэнцэл (ОУВС-гийн тодорхойлолтоор)	0.7	2.7	1.3	-0.7	-1.4	-3.1	-3.1	-3.1	-3.2
Уул уурхайн бус суурь тэнцэл (ДНБ-д эзлэх хувиар)	-6.3	-5.7	-8.9	-7.4	-8.3	-9.4	-9.0	-8.6	-8.2
Санхүүжилтийн нийт хэрэгцээ	3.8	9.0	4.7	5.4	5.6	7.5	7.8	8.6	11.9
Засгийн газрын өр 2/	64.5	45.9	44.5	44.7	46.8	49.5	51.5	53.0	53.7
Дотоод	4.4	2.6	3.2	3.0	3.0	3.2	3.2	3.4	3.6
Гадаад	60.1	43.3	41.3	41.7	43.8	46.4	48.3	49.6	50.1
Мөнгө зээл									
Нийт мөнгөний өсөлт (өөрчлөлт хувиар)	6.5	26.8	15.2	13.4	12.7	11.7	11.8	14.1	11.8
Нөөц мөнгөний өсөлт (өөрчлөлт хувиар)	39.9	7.4	51.9	0.7	12.7	11.7	11.8	14.1	12.7
Зээлийн өсөлт (өөрчлөлт хувиар)	8.6	22.0	30.9	25.0	21.2	19.5	17.5	15.5	15.5
Төлбөрийн тэнцэл									
Урсгал дансны тэнцэл	-13.4	0.6	-10.5	-14.8	-13.1	-13.3	-13.0	-12.9	-12.7
Барааны экспорт	57.5	68.5	62.5	53.6	53.5	51.4	49.8	47.9	46.1
Барааны импорт	50.3	46.1	49.5	46.2	45.1	44.2	43.7	42.9	41.5
Гадаад валютын нийт нөөц (сая ам. доллар)	3400	4922	5510	4566	4627	4669	4864	5045	5212
(импортын сараар)	3.0	3.6	4.0	3.2	3.1	3.0	3.0	3.0	3.0
(банкуудын МБ дахь валютын харилцахын дүнг хасса	1949	3491	4233	...	...	...	...	...	...
Гадаад валютын цэвэр нөөц (NIR) 3/	-788	1152	1768	...	...	...	...	...	...
Валютын ханш									
Төгрөг/ам. доллар (хугацааны эцэст)	3445	3411	3420	...	...	...	...	...	...

Эх сурвалж: Монгол Улсын эрх баригчид, ОУВС-гийн мэргэжилтнүүдийн төсөөлөл.

1/ Энэхүү төсөөллийг одоо яригдаж байгаа 2025 оны төсвийн тодотголоос өмнө боловсруулсан болно. Тус төсөөлөлд өмнөх Засгийн газраас баталсан татварын багц арга хэмжээ тусгагдсан болно.

2/ МҮХБ-ны нийт өр, ТӨК-д олгосон Засгийн газрын баталгаа, ХХБ-ны Эрдэнэт үйлдвэрийн хувьцааны төлбөртэй холбоотой Монголбанканд өгөх Засгийн газрын өр, төлбөрийг тусгасан дүн. Монголбанкны Хятадын ардын банканд холбогдох өр төлбөрийг оруулаагүй болно.

3/ Гадаад валютын цэвэр нөөц гэдэгт гадаад валютын нийт нөөцөөс арилжааны банкууд, ЗГ-ын МБ дахь валютын харилцах, Хятадын ардын банкны своп шугам, ОУВС-д өгөх өглөгийг хассан дүн орно.